



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар A/336

Арвайхээр сум

### Морины уралдаан зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Морин спорт уяачдын “Арвагар хээр” холбооноос зохион байгуулж буй Бүрд суманд 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр бага 3-н насны бүсийн хурдан морины уралдаан, Есэнзүйл суманд 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр том 3-н насны бүсийн хурдан морины уралдаан тус тус зохион байгуулагдах тул морь уралдах зам талбайг засаж, халтиргаа гулгааг арилгах зэргээр замын эрсдэлийг арилгаж, уралдаанч хүүхдийн эрх, хамгаалал аюулгүй байдлыг ханган ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга болон аймгийн морин спорт уяачдын холбоо (Ю.Үнэнбүрэн)-д тус тус үүрэг болгосугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Г.Чимэддавга), аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Цэвээндулам), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг, аймгийн Засаг даргын орлогч (О.Сумьяасүрэн)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

И.ДОРЖСҮРЭН



6224 11 0893